



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 114

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчид барилга байгууламж,
эд хөрөнгө бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 77 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банк болон Европын хөрөнгө оруулалтын банктай байгуулсан "Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр"-ийн дагуу хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр баригдаж, ашиглалтад орсон нийт 16,513,749,617.2 (арван зургаан тэрбум таван зуун арван гурван сая долоон зуун дөчин есөн мянга зургаан зуун арван долоон төгрөг хорин мөнгө) төгрөгийн өртөг бүхий хавсралтад дурдсан барилга байгууламж, тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА

Ж.БАТБАЯСГАЛАН



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн
114. дүгээр тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх дүн /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Бүртгэх байгууллага
1	Сэлбэ дэд төвийн 2 дугаар хэлхээ болон 960 хүүхдийн сургууль 1-р хэлхээ УДДТ12-с 2-р хэлхээний дулаан хангамж, хэрэглээний халуун ус, цэвэр усны шугам сүлжээний ажил, 1ш УДДТ-ийн барилга	Сүхбаатар 13, 14 дүгээр хороо, Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо	2021, 2022	4,189,631,201.93	Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк болон Европын хөрөнгө оруулалтын банктай байгуулсан “Санхүүжилтийн өрөнхий хэлэлцээр”-ийн дагуу ЕХОБ-ны хөнгөлөлтэй зээлийн санхүүжилт	“Хэсэгчилсэн ижинженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ
2	Морингийн даваа орчмын шинэ суурьшлын бүсийн усан сан, насос станцын барилга, шугам сүлжээ	Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо	2023	12,324,118,415.38	Ус Сувгийн Удирдах Газар ОНӨААТҮГ	
НИЙТ ДҮН				16,513,749,617.31		